



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/399

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.10, 5.13 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн салбар үүсэн байгуулагдсаны 106 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийг дүүргийн Засаг даргын нэрэмжит “Өргөмжлөл”-өөр шагнасугай.

2. Засаг даргын нэрэмжит “Өргөмжлөл”-д дагалдах мөнгөн шагналыг холбогдох шагналд тодорхойлсон байгууллагын зардлаас гаргахыг зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /Б.Амартүвшин/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ